

ИРГЭДЭЭС ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА, АЛБАН
ТУШААЛТАНД ГАРГАСАН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫГ
ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАЛААРХ 2018 ОНЫ 2 ДУГААР
УЛИРЛЫН МЭДЭЭНИЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2018.07.05

Арвайхээр хот

Аймгийн Засаг даргын Тамгын газар нь иргэдийн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэхдээ “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай”, “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Засгийн газрын 2005 оны 67 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2008 оны 44 дүгээр захирамжаар батлагдсан “Иргэдээс аймаг, сумын Засаг дарга, түүний Тамгын газар, аймгийн Засаг даргын дэргэдэх хэлтэс албадад гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх тухай журам”-ыг мөрдлөг болгон иргэдэд түргэн шуурхай чирэгдэлгүй үйлчлэх зарчим баримтлан ажиллаж байна.

Мөн иргэдийн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг аймгийн Засаг даргын дэргэдэх Мэдээлэл, шуурхай удирдлагын төвийн 70321111 дугаарын утсаар болон биечлэн авч шийдвэрлэж байна. Тус төвд тайлангийн хугацаанд нийт 784 өргөдөл, гомдол, санал ирснээс 776 буюу 98.9 хувь нь хуулинд заасан хугацаанд шийдвэрлэгдэж, 8 буюу 1.02 хувь нь шийдвэрлэх хугацаа болоогүй байна. Ирсэн өргөдөл, гомдол, саналын 209 нь мэдээлэл, тодруулга, 511 гомдол, 64 санал байна.

Долоо хоног бүрийн Мягмар гаригт хуралддаг аймгийн Засаг даргын дэргэдэх хэлтэс, агентлаг, албадын дарга нарын “Шуурхай хуралдаан”-ыг 25 удаа зохион байгуулж, иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шуурхай шийдвэрлэх талаар байгууллагын удирдлагуудад хугацаатай үүрэг даалгавар өгч, 7032-1111 утсанд иргэдийн ирүүлсэн санал, гомдлыг шийдвэрлэх талаар 29 удаагийн мэдээллийг сонсч, шийдвэрлэлт, хариу өгсөн байдалд дүгнэлт хийж, төрийн үйлчилгээг шуурхай үзүүлэх тал дээр анхаарч ажиллалаа.

2018 оны 2 дугаар улирлын байдлаар аймаг, сумдын Засаг даргын Тамгын газар болон хэлтэс, албадууд, төрийн чиг үүрэг бүхий байгууллага, ажилтанд нийт 12955 өргөдөл, гомдол, санал ирүүлсний өргөдөл 11974 буюу 92.4 хувь, гомдол 784 буюу 6.1 хувь, санал 197 буюу 1.5 хувийг тус тус эзэлж байна.

Ирүүлсэн хэлбэрийн хувьд авч үзвэл бичгээр 11235 буюу 86.7 хувь, утсаар хандсан 1027 буюу 7.9 хувь байна. Аймгийн хэмжээнд нийт 12955 өргөдөл, гомдол, санал ирсний 589 буюу 4.5 хувь нь шийдвэрлэх хугацаа болоогүй, 12366 буюу 95.4 хувь нь хуулийн хугацаанд шийдвэрлэгдлээ.

Ирсэн өргөдөл, гомдлыг агуулгын хувьд авч үзэхэд, нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт, газар өмчлөх, эзэмших хүсэлт, иргэний бичиг баримтын зөрчил арилгуулах, байгууллагын үйлчилгээ, үйл ажиллагаатай холбоотой 10349 буюу 79.8 хувь, шилжилт хөдөлгөөнтэй холбоотой, 1417 буюу 10.9 хувь, материал, мөнгөн тусламж хүссэн 556 буюу 4.3 хувийг тус тус эзэлж байна.

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

ИРГЭДЭЭС ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД
ХАНДАЖ ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ

2018.07.05

Арвайхээр

д/д	Байгууллагын нэр	Нийт өргөдөл, гомдлын тоо	Шийдвэрлэлт			Хугацаа болоогүй	Шийдвэрлэлт
			Шийдвэрлэж хариу өгсөн	Бусад байгууллагад шилжүүлсэн	Хугацаа хэтэрсэн		/Хувь/
1	Аймгийн Засаг даргын Тамгын газар	171	153	19	0	18	89.5%
2	Аймгийн Мэдээлэл шуурхай удирдлагын төв	784	776	784	0	8	99.0%
3	Агентлагийн дүн	576	472	13	21	104	81.9%
4	Сумдын дүн	11424	10965	1570	2	459	96.0%
Дүн		12955	12366	2386	23	589	91.6%

НЭГТГЭСЭН:

АЙМГИЙН ЗДТГ-ЫН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ
УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

П.МӨНХЗУЛ

ХЯНАСАН:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

Ц.ГАНБОЛД

ИРГЭДЭЭС ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД
ХАНДАЖ ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, САНАЛ, ХҮСЭЛТ /ХЭЛБЭРЭЭР/

2018.07.05

Арвайхээр

д/д	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлт	Үүнээс:						
			Бичгээр	Засгийн газрын 11-11 төв	Аймгийн МШУТөв, 7032-1111	Цахимаар	Утсаар	Биечлэн	Бусад
1	Аймгийн Засаг даргын Тамгын газар	171	149	22	-	-	-	-	-
2	Агентлагийн дүн	576	447	2	69	-	24	31	3
3	Сумдын дүн	11424	10630	1	8	3	231	541	10
4	МШУТөв	784	9	2	-	-	772	1	-
	Дүн	12955	11235	27	77	3	1027	573	13

НЭГТГЭСЭН:

АЙМГИЙН ЗДТГ-ЫН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ
УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

П.МӨНХЗУЛ

ХЯНАСАН:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

Ц.ГАНБОЛД

ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, САНАЛ, ХҮСЭЛТИЙН АГУУЛГА /ХУВИАР/

2018.07.05

Арвайхээр

Аймгийн нэр	/тоо, нийт өргөдөл, гомдолд эзлэх хувь/			
Өвөрхангай аймаг	Нийт өргөдөл, гомдол, санал 12955 ирсэн байна.	Хүсэлт	11974	92.4%
		Гомдол	784	6.0%
		Санал	197	1.5%
	Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт, газар өмчлөх, эзэмших хүсэлт, иргэний бичиг баримтын зөрчил арилгуулах, нийгмийн даатгалт, байгууллагын үйлчилгээ үйл ажиллагаатай холбоотой асуудлууд	10349	79.8%	
	Шилжилт хөдөлгөөн	1417	10.9%	
	Материал, мөнгөн тусламж хүссэн	556	4.2%	
	Ажилд орох, чөлөөлүүлэх	287	2.2%	
	Тэтгэвэр тогтоолгох, халамжтай холбоотой	253	1.9	
	Сургууль, курст суралцах	53	0.4%	
	Гэр, орон сууц хүссэн	40	0.3%	
<ul style="list-style-type: none"> • Аймгийн Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн 70321111 утсанд 784 иргэн хандаж, цаг үеийн шинжтэй мэдээллийг 209 иргэнд өгсөн байна. • Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 63 дугаар тогтоолоор Арвайхээр суманд Зүлэгтийн 12, Онгийн 13 дугаар баг шинээр байгуулагдсантай холбогдуулан иргэний бичиг баримтын өөрчлөлт, шилжилт хөдөлгөөний асуудал их байна. 				

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР